



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 638

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 16/07/051/83, Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын улсын ахлах байцаагчийн 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 02-27-01/084/10 дугаар дүгнэлтээр тус тус тогтоогдсон, 3 нэрийн, нийт 35,660,800.00 (гучин таван сая зургаан зуун жаран мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа М.Адъяабаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан барилга байгууламжийн доорх Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байрлах 3402 м.кв газарт гамшгийн эрсдэлийн төвийн барилга барих, нөхөн сэргээх, зориулалтаар нь ашиглах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) -г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны ... дугаар сарын ... өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр байршил	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Конторын барилга (Өмнөговь аймаг Даланзадгад сум)	1958	1	30,762,890.00	30,762,890.00	-
2	Уурын зуух (Өмнөговь аймаг Даланзадгад сум)	1975	1	1,197,910.00	1,197,910.00	-
3	Зоорь хүнсний ногоо (Өмнөговь аймаг Даланзадгад сум)	2012	1	3,700,000.00	3,700,000.00	-
Нийт дүн			3	35,660,800.00	35,660,800.00	-
				(гучин таван сая зургаан зуун жаран мянга найман зуу)	(гучин таван сая зургаан зуун жаран мянга найман зуу)	